МҮХАҮТ

11-Р САРЫН ТОЙМ





БУСАД НҮҮРЭНД



Монгол, Канадын хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх уулзалт боллоо




Зүүн бүсийн бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, боломжийг нээх уулзалт–семинар зохион байгуулагдлаа



“MOCK TRIAL 2026” арбитрын мэтгэлцээний тэмцээн боллоо



БНСУ–ын BHC Chicken брэнд Монголд нэвтэрлээ



“Танхимтай танилцах аян” амжилттай зохион байгуулагдлаа



MYXAYT Ази, Номхон далайн бүсийн хөдөлмөр эрхлэлтийн форумд оролцлоо



Монголын Олон Улсын Арбитр “JCAA Global Arbitration Forum 2026” форумд оролцлоо



Бизнесийн орчны судалгааны дүнг ирэх сард танилцуулна



МҮХАҮТ–ын Ерөнхийлөгч Польш Улсын парламентын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа



Хөдөө аж ахуйн салбарт хосмог сургалт хэрэгжүүлэх боломжийг хэлэлцлээ



Мобикомын дата төвийн үйл ажиллагаатай танилцлаа



Гарал үүслийн цахим гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг хэлэлцлээ

11-Р САРЫН ТОЙМ

Монгол, Канадын хөдөө аж ахуйн салбарын хамтын ажиллагааг өргөжүүлэх уулзалт боллоо





Канад Улсын Ванкувер хотод болсон уулзалтаар МҮХАҮТ-ын дэд захирал Ч.Баттулга тэргүүтэй бизнесийн төлөөлөгчид малын генетик, үржил селекц, мал эмнэлэг, дэвшилтэт технологийн чиглэлээр хамтран ажиллах боломжийг хэлэлцлээ.


“MOCK TRIAL 2026” арбитрын мэтгэлцээний тэмцээн эхэллээ



Монголын Олон Улсын Арбитраас хууль зүйн их, дээд сургуулийн бакалаврын түвшний оюутнуудын дунд жил бүр зохион байгуулдаг арбитрын мэтгэлцээний тэмцээн эхэллээ.



“Танхимтай танилцах аян” амжилттай зохион байгуулагдлаа





Бизнес эрхлэгч залуучуудын зөвлөлөөс гишүүддээ зориулан зохион байгуулсан аяны хүрээнд МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав бизнесийн орчин, эдийн засгийн нөхцөл байдал, хувийн хэвшлийн тулгамдсан асуудал, боломжийн талаар мэдээлэл өглөө.

Монголын Олон Улсын Арбитр “JCAA Global Arbitration Forum 2026” форумд оролцлоо



Монголын Олон Улсын Арбитрын дарга С.Энхцэцэг Япон Улсад болсон олон улсын форумд оролцож, Ази тивд арбитрын хөгжлийг өргөжүүлэх, институцийн чадавхыг бэхжүүлэх сэдэвт панел хэлэлцүүлэгт илтгэл тавилаа.

Бизнесийн орчны судалгааны дүнг ирэх сард танилцуулна

Монгол Улсад бизнес эрхлэх нөхцөл байдлыг цогцоор нь үнэлэх Бизнесийн орчны судалгааны үр дүнг 2026 оны арванхоёрдугаар сард эцэслэн боловсруулж, олон нийтэд танилцуулна.



Зүүн бүсийн бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, боломжийг нээх уулзалт-семинар зохион байгуулагдлаа





Канадын Засгийн газрын Орон нутгийн санаачилгыг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан уулзалт-семинарт Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн бизнес эрхлэгчид оролцож, ESG, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хүний эрх, бизнесийн манлайлал, хиймэл оюун ухаан зэрэг сэдвээр мэдлэг, туршлага солилцлоо.

БНСУ-ын BHC Chicken брэнд Монголд нэвтэрлээ





МҮХАҮТ-ын гишүүн Ази Фарма ХХК БНСУ-ын BHC Chicken брэндийг Монголын зах зээлд нэвтрүүлэх франчайзын гэрээ байгууллаа. Гэрээнд гарын үсэг зурах ёслолд МҮХАҮТ-ын удирдлагууд оролцов.

МҮХАҮТ Ази, Номхон далайн бүсийн хөдөлмөр эрхлэлтийн форумд оролцлоо

Олон улсын хөдөлмөрийн байгууллага болон БНСУ-ын хамтын ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд Тайландын Бангкок хотод зохион байгуулагдсан бүсийн форумд МҮХАҮТ оролцож, хөдөлмөр эрхлэлт, ур чадвар, технологийн өөрчлөлт болон ажил олгогчдын оролцооны асуудлаар санал солилцлоо.



МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Польш Улсын парламентын төлөөлөгчдийг хүлээн авч уулзлаа



МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав, Гүйцэтгэх захирал Ц.Магнайбаатар нар Польш Улсын Сеймийн дэд маршал Дорота Ниэджиэла тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

11-Р САРЫН ТОЙМ

Хөдөө аж ахуйн салбарт хосмог сургалт хэрэгжүүлэх боломжийг хэлэлцлээ





Хөдөө аж ахуйн салбарын хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн хүний нөөц бэлтгэх, мэргэжлийн боловсролын хосмог сургалтыг хэрэгжүүлэх хэрэгцээ, нөөц боломжийг хэлэлцсэн нээлттэй өдөрлөг зохион байгуулагдлаа.

Гарал үүслийн цахим гэрчилгээг харилцан хүлээн зөвшөөрөх асуудлыг хэлэлцлээ



Хөнгөлөлттэй бус гарал үүслийн цахим гэрчилгээг улс хооронд харилцан хүлээн зөвшөөрөх Үндэсний ажлын хэсгийн өргөтгөсөн хуралдаанаар эрх зүйн болон техникийн орчин, экспортлогч, импортлогчдод тулгарч буй асуудлуудыг хэлэлцлээ.

МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Беларусь Улсын Элчин сайдтай уулзлаа





МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав Беларусь Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Михаил Сергеевич Ордатай уулзаж, 2026 оны бизнес форумын хүрээнд байгуулсан 17 гэрээ, санамж бичгийн хэрэгжилт болон 2027 онд тохиох дипломат харилцааны 35 жилийн ойн хүрээнд хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар санал солилцлоо.

Монгол, Японы эх, хүүхдийн хувцас үйлдвэрлэгчид хамтран ажиллана





Монголын “Сүүн Цахирмаа” ХХК болон Японы Step Gaomei компани үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмжийн шинэчлэл, хүний нөөцийн хөгжлийн чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг байгууллаа. Арга хэмжээнд МҮХАҮТ-ын дэд дарга Ч.Баттулга оролцов.

Мобикомын дата төвийн үйл ажиллагаатай танилцлаа





“Энтрепренёр” шилдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаатай танилцах аяллын хүрээнд МҮХАҮТ-ын гишүүн байгууллагуудын төлөөлөл Мобиком Корпораци ХХК-ийн дата төв, технологийн шийдэлтэй танилцаж, туршлага судаллаа.

МҮХАҮТ Турк Улстай чөлөөт бүсийн салбарт хамтран ажиллах сонирхлоо илэрхийллээ





МҮХАҮТ-ын Ерөнхийлөгч Б.Лхагважав Турк Улсын Худалдааны яамны Чөлөөт бүсийн ерөнхий газрын төлөөлөлтэй уулзаж, хөрөнгө оруулалт, чөлөөт бүсийн хөгжил болон бизнесийн хамтын ажиллагааны талаар санал солилцлоо.

“Ур чадвар – Миний ирээдүй” өдөрлөгт МҮХАҮТ оролцлоо





Залуучуудад мэргэжлээ зөв сонгох, ур чадвараа хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх өдөрлөгийн хүрээнд МҮХАҮТ хосмог сургалтын үр өгөөжийг танилцуулж, ажил олгогчдын оролцоо, ажлын байран дахь дадлагажуулагчдыг бэлтгэх чиглэлээр оролцлоо.

Эрчим хүчний зөвлөлийн ээлжит хурал боллоо





МҮХАҮТ-ын дэргэдэх Эрчим хүчний зөвлөлийн ээлжит хуралд 58 гишүүн оролцож, Зөвлөлийн дарга Д.Ганхуяг 2026 оны үйл ажиллагааны тайланг танилцууллаа.